

ХҮҮХДИЙН СЭРГЭЭН ЗАСАХ ХАН ТУУЛ ТӨВИЙН
2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН СУРГАЛТЫН ТАЙЛАН

2026.05.30

№	Сургалтын сэдэв	Хариуцах байгууллага, албан тушаалтан	Сургалт орсон хугацаа	Хэрэгжилт
Мэргэжлийн байгууллагаас авах сургалт /Гадаад сургалт/				
1	Амь тэнссэн яаралтай үеийн тусламж, авах арга хэмжээ Амилуулах суурь тусламж	II-р эмнэлгийн ЯТТ /Төвийн ЯТ эмч/	2026.05.18	УХТЭ-ийн ЯТ-ийн тасгийн эрхлэгч Ж. Уламсайхан төвийн 22 ажилтанд “зарлан мэдээллэх өнгөт дохиоллын тогтолцоо”-ны талаар сургалтыг 05 сарын 18-ны 15:00-17:00 хороонд зохион байгуулсан. Сургалтаар ажилчдад дараах мэдээллийг өгсөн: - Өнгөт дохиоллын үүсэл гарал - Олон улсын өнгөт дохиоллын өнгө болон тайлбар - УХТЭ-ийн өнгөт дохиоллын код, тэдгээрийн тайлбар - Өнгөт дохиоллын хэрэглээ, өөрийн байгууллагад хэрэглэх арга, зөвлөгөөний талаар мэдээллийг хүргэсэн.
2	Чанар сайжруулах арга хэмжээ	Монголын чанарын менежерүүдийн холбоо /Төвийн чанарын менежер/		
3	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн харилцаа хандлага	/Төвийн чанарын менежер/	2026.05.15	Монголын үйлдвэрчний эвлэлийн хуульч М. Саранцацрал “эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ” сэдвээр төвийн 30 ажилтанд сургалт зохион байгуулсан. Сургалтаар: - Ёс зүй болон ёс суртахууны ялгаа

				- Удирдах ажилтны нэмэлт үүрэг - Эмнэлгийн мэргэжилтний хориглох улаан шугам - Харилцааны 3 хэмжээс, ёс зүйн хэрэглээ - Хүнлэг харилцаа ба мэдээлэлжүүлсэн зөвшөөрөл - Нийгэм, олон нийтийн эрх ашгийг хувийн ашиг сонирхлоос илүүд үзэх - Төрийн албан хаагчийн ёс зүй - Ажлын байрны харилцааны соёл ба 5 зарчим - Ёс зүйн зөрчилд анхаарах 5 дохио - Ёс зүйн хорооны бүтэц, чиг үүрэг - Зөрчил гаргасан тохиолдолд хүлээх хариуцлагын шатлал зэрэг мэдээллүүдийг өгсөн.
4	Авлигатай тэмцэх тухай хууль	Авлигатай тэмцэх газар	2026.02.10	Авлигатай тэмцэх ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх комиссар С. Янжинлхамтай хамтран төвийн 22 ажилчдад “Авлигын эсрэг суурь ойлголт, мэдээлэл” сэдэвт сургалтыг 2026 оны 02 сарын 10-ны өдөр зохион байгууллаа. • “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилсан сэргийлэх нь” • “Авлигын шалтгаан нөхцөл, хор хөнөөл” зэрэг сэдвээр дэлгэрэнгүй танилцуулга, мэдээлэл хийж сургалтад оролцогчдын асуултад хариулж, авлигаас урьдчилан сэргийлэх талаар мэргэжил, арга зүйн заавар, зөвлөгөө өгөв.
5	Гамшгийн үед авах арга хэмжээ	Хан уул дүүргийн Улайн загалмайн нийгэмлэг	05/14	Хан Туул хүүхдийн сэргээн засах төв Хан-уул дүүргийн онцгой байдлын хэлтсийн дэслэгч Д. Энхжаргалтай хамтран 2026 оны 05 дүгээр сарын 13-ны өдөр төвийн нийт 22 ажилчид дунд “Гал түймэр унтраах тархалтын дадлага” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар гал түймрийн

				аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлаа хангах талаарх мэдлэг олгож гал гарах үед авах арга хэмжээ, галын хор ажиллуулах үзүүлэн сургалтыг зохион байгууллаа. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлаа хангах, ахуйн хүрээний гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар төвийн нийт ажилтан нарт мэдлэг олгосон.
6	Хөдөлмөрийн аюулгүй байдал	Нийслэлийн үйлдвэрчний эвлэлийн хороо	03/31	Сургалтын илтгэгч багшаар Нийслэлийн Ажил олгогч эздийн Холбооны дарга Р.Ганхуяг ажиллаж, асуултад хариуллаа. Тус сургалтаар: • Эрсдэл гэж юу вэ? • Эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга болон эерэг нөлөө • Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ • Хөдөлмөрийн сөрөг хүчин зүйлийн нөлөөлөл • Хөдөлмөрийн эрүүл ахуй түүнд тавигдах шаардлага • ХАБЭА-н өнөөгийн нөхцөл байдал зэргээр төвийн нийт 23 ажилтнуудад мэдээлэл хүргэсэн.
7	Эрүүл мэндийн салбар дах хүүхэд хамгаалал	ХУД, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс ЭМНА Б. Ганцэцэг	03/02	Хан-Уул дүүргийн Хүүхэд, Гэр бүлийн Хөгжил Хамгааллын Хэлтэс, Хан-Уул дүүргийн 3 дугаар хорооны Хамтарсан баг, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төлөө “Галт шувуу” НҮТББ-ын хамтын оролцоотойгоор сургалтыг 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 12 цагт Хүүхдийн сэргээн засах “ХАН-ТУУЛ” төвийн байранд болж 1 цаг 30 минутын сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад нийт 17 ажилтан албан хаагчид оролцсон. Сургалтыг Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төлөө “Галт шувуу” холбоо НҮТББ-ын

				гүйцэтгэх захирал, кейс менежментийн мөнгөн түвшний сургагч багш, хүүхэд хамгааллын зөвлөх Э.Дуламсүрэн багш удирдаж, Хүүхэд, Гэр бүлийн Хөгжил Хамгааллын Хэлтсийн хороо хариуцсан хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан Ё.Ундрэм, Б.Чинбат нар туслан гүйцэтгэж хамтран ажилласан. Сургалтаар: • Эрүүл мэндийн салбар дах хүүхэд хамгаалал • Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх • Хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй хүүхдийг мэдээлэх • Хүүхдийн хүчирхийллийн талаар ерөнхий ойлголтын талаар мэдээллийг өгч асуулт, хариултаар өндөрлөсөн
Ажлын байранд явагдах мэргэжлийн сургалт /Дотоод сургалт/				
1	Улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх / Цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой /	Сувилагч Мөнхцэцэг	01/13	Төвийн 12 ажилтанд Сувилагч Д.Мөнхцэцэг цаг үеийн байдалтай холбоотойгоор “Улаанбурхан өвчин”-ний талаар сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтаар: • Улаанбурхан өвчний талаар ерөнхий мэдээлэл • Улаанбурхан өвчний шинж тэмдэг, авах арга хэмжээ • Урьдчилан сэргийлэх арга хэмжээ • Халдвар дамжих зам • Монголын өнөөгийн байдал, тоо баримт зэрэг мэдээллүүдийг багтаан хүргэсэн.
2	Асран хамгаалагчдыг чадваржуулах / ДЭМБ хөтөлбөр танилцуулах хөтөлбөр /	Хүүхдийн эмч Г. Сэржхорлоо ЭМНА Б. Ганцэцэг	01/27	2025-2026 оны хооронд Монголын Аутизмын холбооноос зохион байгуулсан “Асран хамгаалагчдын ур чадварыг сайжруулах сургалт (CST)”-д Хүүхдийн сэргээн засах Хан туул төвийн хүүхдийн их эмч Г. Сэржхорлоо,

				НЭМА Б. Ганцэцэг нар сууж сургагч багш болсон. Үүнтэй холбоотой төвийн 14 ажилтанд хүүхэдтэй ажиллах арга зүй, асран хамгаалагч нарт өгөх зөвлөгөө, хүүхдийн сөрөг зан үйлд үзүүлэх хариу арга хэмжээ, хүүхдийн чадварыг сайжруулахад асран хамгаалагч нарын оролцоо, дэмжлэг зэрэг мэдээллийг хүргэсэн.
3	Төвийн хэмжээнд хэрэглэгдэж буй эмийн жагсаалт, тун хэмжээ, хэрэглэх заалт	Хүүхдийн их эмч Г. Сэржхорлоо	03/10	Хан туул төвийн хүүхдийн их эмч Г. Сэржхорлоо төвийн 11 ажилтанд сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар: • Эмийн жилийн төсөв 3,0- сард-250 эм, эмнэлгийн хэрэгсэл хэрэглэх, /хэмнэлт/ • Төвийн хэмжээнд нөөцөд бүртгэлтэй эм, тариа эмнэлгийн хэрэгсэл • Хүүхдэд хэрэглэх эмийн тун, хэмжээ • Антибиотик • Вирусын эсрэг эм • Өвдөлт намдаах, халуун бууруулах эм, лаа, наалт • Харшилын эсрэг эм, тосон түрхлэг • Гуурсан хоолой тэлэх эм • Пробиотикууд • Цайрын бэлдмэлүүд • Амин дэмүүд • Мультивитамин
4	Эрэмбэлэн ангилалт	ЯТ их эмч Б. Санчирмаа	03/24	Хан туул төвийн ЯТ их эмч Б. Санчирмаа төвийн 13 ажилтанд сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар: ЭМС-ийн 2018 оны А/489 тоот тушаал: Эрүүл мэндийн байгууллагад тусламж, үйлчилгээ авахаар ирж буй хүүхдийг дараах ангиллаар эрэмбэлж тусламж, үйлчилгээг үзүүлнэ. Үүнд: 1. Яаралтай шинж тэмдэг бүхий хүүхэд, 2. Тулгамдсан шинж тэмдэг бүхий хүүхэд,

				3. Яаралтай тусламж одоогоор шаардлагагүй хүүхэд гэж ангилна. Эрүүл мэндийн байгууллагын хүлээн авах, яаралтай тусламжийн тасаг, нэгжийн эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн, ажилтнууд хүүхдийн амь тэнссэн байдлыг нь харж, 15-20 секундэд шуурхай үнэлэх, мэргэжлийн эмч иртэл анхны тусламж үзүүлэх чадварыг эзэмшсэн байх шаардлагатай талаар мэдээлэл хүргэсэн. Хүүхдийн эрэмбэлэн ангилалтын зэрэг, өнгө, авах арга хэмжээний талаар мэдээлэл хүргэсэн.
5	Гар угаах халдваргүйжүүлэх	Туслах сувилагч Т. Нямдэлгэр	04/07	ЭМС-ын 2019 оны А/537 тоот тушаалын дагуу төвийн нийт 14 ажилтанд халдвараас сэргийлэх мэдлэгийг бататгах үүднээс гар угаах дараалал, , гарын эрүүл ахуй сахих 5 мөч, гар халдваргүйжүүлэх дараалалын талаар мэдлэг бататгах сургалтыг туслах сувилагч Т. Нямдэлгэр зохион байгуулсан.
6	Эмнэлэгт үйлчлүүлэгч тээвэрлэх журам	ЭТҮХОД	04/21	Монгол улсын эрүүл мэндийн сайдын 2023 оны 06 сарын 22 өдрийн А/220 дугаар тушаал, хүүхдийн сэргээн засах төвийн даргын 2024 оны 04 сарын 24 өдрийн А/14 дугаар тушаалд заасны дагуу үйлчлүүлэгчийг тээвэрлэх талаар 13 ажилтанд сургалтыг зохион байгуулсан. Үйлчлүүлэгчийг аюулгүй тээвэрлэх, зөөвөрлөхөд шаардлагатай зүйлсийн хэрэгслийн бүрэн байдлын талаарх зураг, жагсаалтыг танилцуулсан. Аюулгүй тээвэрлэлтийн ач холбогдол, үйлчлүүлэгчийн тээвэрлэлтийн төрөл тээвэрлэлтийн шийдвэр болон тээвэрлэлтийн зөвшөөрлийн хуудас зэргийг танилцуулсан
7	Тохиолдол бүртгэх, мэдээллэх журам	Сувилагч Ч. Оюунчимэг	05/05	Хан Туул хүүхдийн сэргээн засах төвийн ЯТ сувилагч Ч. Оюунчимэг 2026 оны 05 дүгээр сарын 05-ны өдөр төвийн нийт 15 ажилчид

				дунд “Тохиолдол бүртгэх, мэдээллэх журам” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар ЭМС-ын 2024 оны А/112 тоот тушаалыг танилцуулан мэдлэгийн бататгасан. Журмын дагуу тохиолдлуудын төрөл, тохиолдлуудыг шийдвэрлэх зорилтууд, эмнэл зүйн болон эмнэл зүйн бус шалтгааны тодорхойлолт, сөргөөр нөлөөлөх хүчин зүйл зэргийг тайлбарласан.
8	Эрүүл мэндийн байгууллагын цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэл	Туслах сувилагч Д. Энхмандах	05/19	Төвийн туслах сувилагч Д. Энхмандах 11 ажилтанд сургалт зохион байгуулсан. Сургалтаар ЭМС-ын 2019 оны А/537 тоот тушаалын 6 дугаар хавсралтын дагуу танилцуулаг хийсэн. Агуулга: - Цэвэрлэгээний ерөнхий зарчим - Цэвэрлэгээнд хэрэглэх материалын өнгө - Халдварын эрсдэлийн бүсийн цэвэрлэгээ зэргийг тайлбарлан төвийн хэмжээнд хийгдэж байгаа цэвэрлэгээ, хуудас хөтлөлт зэргийг танилцуулсан.

Тайлан гаргасан НЭМА

Б. Ганцэцэг